# ТОВЧИЛСОН ҮГС

| | |
|---|---|
| БОАЖГ | БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР |
| БОАЖЯ | БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ |
| БОМТ | БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ |
| БОНЕҮ | БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ |
| БОННҮ | БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭ |
| ХАБЭА | ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ |
| ХЭМАБ | ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДАЛ |

## АГУУЛГА


**БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ..... 4**
1.1. ОРШИЛ 4
2.1. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ 5
2.2. ТӨСЛИЙН БАЙРШИЛ 5
**БҮЛЭГ 2. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОДОРХОЙЛОЛТ ..... 7**
**БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ ..... 8**
3.1. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ 8
3.2. БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ 8
3.3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ 10
**БҮЛЭГ 4. ТЖБОМТ-НИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ ..... 13**
4.1. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮНДЭСЛЭЛ 13
4.2. ТЖБОМТ-ний ЗОРИЛГО, АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ҮР ДҮН 13
4.3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИй хамрах хүрээ **Error! Bookmark not defined.**
**БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ ..... 16**
**БҮЛЭГ 6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ..... 19**
**БҮЛЭГ 7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ ..... 19**
**БҮЛЭГ 8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨ ..... 19**
**БҮЛЭГ 9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ ..... 21**
**БҮЛЭГ 10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ..... 23**
**БҮЛЭГ 11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ..... 28**
**БҮЛЭГ 12. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР ..... 31**
**БҮЛЭГ 13. ТЖБОМТ-Г ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ ..... 35**
**БҮЛЭГ 14. ТЖБОМТ-НИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ ..... 38**
**БҮЛЭГ 15. ТӨСЛИЙН 2023 ОНЫ БОМТ-НИЙ НИЙТ ЗАРДАЛ ..... 39**
**БҮЛЭГ 16. ХОЛБОГДОХ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ ..... 40**
16.1. БАЙГАЛЬ ОРЧИН, ЭРҮҮЛ МЭНД БОЛОН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ СТАНДАРТУУД 41
**АШИГЛАСАН МАТЕРИАЛ ..... 47**
**ХАВСРАЛТ МАТЕРИАЛ .....** ERROR! BOOKMARK NOT DEFINED.


## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ


Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл ..... 5
Хүснэгт 2. Үйлдвэрийн талбайн координат ..... 5
Хүснэгт 3. Төслийн талбайн байгаль орчны төлөв байдлын тодорхойлолт ..... 7
Хүснэгт 4. Нөлөөллийг тооцох аргачлал ..... 8
Хүснэгт 5. Байгаль орчинд нөлөөлөх байдлыг тодорхойлох шалгуур ..... 9
Хүснэгт 6. Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ ..... 10
Хүснэгт 7. Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ ..... 11
Хүснэгт 8. Байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний зардал ..... 16

Хүснэгт 9. Байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний зардал ... 16
Хүснэгт 10. Орчны тохижилт, ногоон байгууламжийн төлөвлөгөө ... 19
Хүснэгт 11. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө ... 23
Хүснэгт 12. Осол эрсдлийн меэежментийн төлөвлөгөө ... 21
Хүснэгт 13. Хог хаягдлын менежентийн төлөвлөгөө ... 24
Хүснэгт 14. Ангилан ялгах хог хаягдлууд ... 33
Хүснэгт 15. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө ... 36
Хүснэгт 16. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр хэрэгжүүлэх зардал ... 33
Хүснэгт 17. Байгаль орчны менежментийн хүрээнд хэрэгжүүлэх ажил ... 36
Хүснэгт 18. Нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал ... 36
Хүснэгт 19. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөл сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө ... 37
Хүснэгт 20. Байгаль орчны төлөвлөгөөт аудитын зардал ... 37
Хүснэгт 21. Төсөлтэй холбоотой зардал ... 43
Хүснэгт 22. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал 1 жилээр ... 39
Хүснэгт 23. Төсөлтэй холбоотой хууль тогтоомжууд ... 40
Хүснэгт 24. Мөрдөж ажиллах стандартууд ... 41
Хүснэгт 25. Стандартуудын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ... 43

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн талбайн байршлын зураг ... 6
Зураг 2. Хог хаягдлын цэгийн шийдэл ... 25
Зураг 3. Орчны хяналт шинжилгээний цэгийн байршлын зураг ... 25

# БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

## 1.1. ОРШИЛ

Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын 1-р багийн нутагт орших Нүүрсийг хуурай аргаар баяжуулах үйлдвэр төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн ажлыг “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”-ын 4.13-т хэрэгжиж буй төслийн ТЭЗҮ, зураг төсөл, нөөц, хүчин чадал, техник, технологийг шинэчлэх тохиолдолд БОННҮ-ний тайланд хийнэ гэж заасны дагуу “Саусгоби даймонд” ХХК -ийн хүсэлтийн дагуу гэрээ байгуулан хийж гүйцэтгэв.

Тус ажлын үндэслэл нь Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний шинжилгээ хийх журам”, БОУАӨЯ-ны шинжээчийн гаргасан ерөнхий үнэлгээний дүгнэлтэд тавьсан шаардлага зэргийг үндэс болгосон ба байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх талаар Байгаль орчин, ногоон хөгжлийн Сайдын 2014 оны 04 сарын 10 -ны өдрийн А-117 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал" зэргийг баримталсан болно.

“Саусгоби даймонд” ХХК нь “Таван толгой” ХК-ийн уурхайг түшиглэн жилд 500.0 мян.т нүүрс баяжуулах хүчин чадалтай үйлдвэрийг барьж, үйл ажиллагаагаа явуулахаар бэлэн болоод байна. Нүүрсийг хуурай аргаар баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулснаар нүүрсний үнслэгийг бууруулж, зах зээлд өрсөлдөхүйц коксжих нүүрс гарган БНХАУ-ын хэрэглэгчдэд эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, экспортлох юм.

Тус баяжуулах үйлдвэр нь хуурай аргаар нүүрсийг баяжуулан коксжих нүүрс үйлдвэрлэж, зах зээлд нийлүүлэх 10 жилийн хугацаатай төслийг хэрэгжүүлэхээр боловсруулсан. Жилд 500.0 мян.т нүүрс баяжуулж, 360.0 мян.т сул коксжих нүүрс, 61.0 мян.т коксжих чанаргүй нүүрс гаргана.

Төслийн эдийн засгийн тооцоогоор үйлдвэрийн нийт хөрөнгө оруулалт 16.2 тэрбум төгрөг байна. Үүнээс баяжуулах үйлдвэрт 4.46 тэрбум төгрөг, үйлдвэрлэлийн удирдлагад 0.96 тэрбум төгрөг, дэд бүтэц 0.82 тэрбум төгрөг байна. Нүүрс баяжуулах үйлдвэр нь улс, орон нутгийн төсөвт жилд 15.1 тэрбум төгрөгийг татвар, төлбөрийн хэлбэрээр оруулна. Баяжуулах үйлдвэрийн ашгийн дотоод норм /IRR/ 23.5 %, ирээдүйн мөнгөний өнөөгийн үнэ цэнэ /NPV 10 %/ 9.9 тэрбум төгрөг байна

АҮЭБЯ-АМГТГ- ЭБМЗ-ийн дүгнэлтээр 2023 оны 11 сарын 01-ны өдрийн т/23-18-05 тоот дүгнэлт, АМГТГ-ын даргын 2025 оны 01 сарын 24-ий өдрийн Т/16 тоот тушаалаар батлагдсан.

2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө /БОМТ/-г Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралт “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу хийж гүйцэтгэлээ.

## 2.1. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

**Төслийн нэр:** Нүүрсийг хуурай аргаар баяжуулах үйлдвэр төсөл

**Төслийн зорилго:** Энэхүү төслийн зорилго нь байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатайгаар хуурай аргаар нүүрсийг баяжуулан эцсийн бүтээгдэхүүний экспортын хэмжээг нэмэгдүүлж эдийн засгийн өсөлтөнд бодитой хувь нэмэр оруулахад оршино.

**Төслийн товч тодорхойлолт:**

ЭБМЗ-ийн 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн Т/23-18-05-01-03 тоот дүгнэлт, АМГТГ-ын 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн Т/139 дугаар тоот тушаалаар нөөцийг баталсан.

Тус талбайн нөөцийг 1200 м үнэмлэхүй өндрөөс дээш буюу үр ашигтай нөөц, доош буюу тодорхой нөхцөлд үр ашигтай нөөц гэж хуваан тооцсон байна.

8 давхраас бүхий 29 үе багцын хэмжээнд 170 блокоор ордын нөөцийг тооцоолсон байна. Ордын хэмжээнд А зэрэглэлийн 24 блок, В зэрэглэлийн 81 блок, С зэрэглэлийн 46 блок, $P_1$ зэрэглэлийн 12 блок, $P_3$ зэрэглэлийн 2 блок, өгөршсөн нүүрсний 5 блок байна.

Өнөөгийн байдлаар тус ордын үлдэгдэл нөөц нь А+В+С зэрэглэлээр чанартай 217,618.3 мян.т, өгөршсөн 710.1 мян.т нүүрс байна.

8-р давхраасны нөөц нь А зэрэглэлийн 2 блок, В зэрэглэлийн 9 блок, С зэрэглэлийн 11 блок байна. А+В+С зэрэглэлээр нийт 37.51 сая т нөөцтэй ба коксжих нүүрсний нөөц нь 7.3 сая т байна. 4-р давхраасны нөөц нь А зэрэглэлийн 9 блок, В зэрэглэлийн 21 блок, С зэрэглэлийн 9 блок байна. А+В+С зэрэглэлээр нийт 65.13 сая т нөөцтэй ба коксжих нүүрсний нөөц нь 11.2 сая т байна. 8 болон 4-р давхраасны коксжих нүүрсний нийт нөөц нь 18.5 сая т байна.

**Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага:**

***Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл***

| | |
|---|---|
| **Аж ахуйн нэгжийн нэр** | “Саусгоби даймонд” ХХК |
| **Улсын бүртгэлийн дугаар** | 1111004112 |
| **Регистрийн дугаар** | 3616703 |
| **Хаяг** | email: bilgiintseel@gmail.com, Утас: 88661984 |

## 2.2. ТӨСЛИЙН БАЙРШИЛ

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын төвөөс зүүн урагшаа 68 км зайд, Баян-Овоо сумын нутаг дахь Зайрмагтай нэртэй талбайд нүүрс баяжуулах үйлдвэр байрлана. “Саусгоби даймонд” ХХК нь үйлдвэрлэлийн зориулалтаар 5.0 га газрыг авч 2011 онд тус үйлдвэрийг барьж байгуулсан. Баяжуулах үйлдвэр нь “Таван толгой” ордоос Цагаан хадны хилийн боомт хүртэл байгуулсан хатуу хучилттай авто замаас 2.0 км зайд байрлаж байна.

***Хүснэгт 2. Үйлдвэрийн талбайн координат***

| № | Уртраг | Өргөрөг |
|---|---|---|
| 1 | 584,364.245 | 4,797,802.388 |
| 2 | 584,560,840 | 4,797,655,850 |
| 3 | 584,439,569 | 4,797,496,336 |
| 4 | 584,245,880 | 4,797,643,590 |




*Зураг 1. Төслийн талбайн байршлын зураг*

# БҮЛЭГ 2. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

***Хүснэгт 3. Төслийн талбайн байгаль орчны төлөв байдлын тодорхойлолт***

| Байгаль орчны төлөв байдлын тодорхойлолт | |
|---|---|
| **Физик газарзүй** | Монгол орны нутаг дэвсгэрийн физик газарзүйн мужлалаар энэ нутаг нь Говийн их мужийн Дорнод говийн мужид, Умард говийн ухаа толгодорхог тал бүхий тойрогт, уур амьсгалын мужлалаар хүйтэн өвөлтэй мужийн гандуу дулаан зунтай бүсэд тус тус хамааруулжээ. |
| **Уур амьсгалын нөхцөл** | Өмнөговь аймаг Төв Азийн хуурай, хуурайдуу говь, цөлийн бүсэд багтаж далайн түвшнээс дээш 1300-1600 метрийн дундаж өндөрт оршино. Эх газрын хуурай сэрүүн, эрс тэс уур амьсгалтай, өргөрөгийн дагуу буюу баруун талын уулархаг нутгаасаа зүүн тийш болох тусам дулаан, хуурай агаартай, хөрснөөс уурших чийгийн нөөц бага, агаар нэн хуурай учраас хур тунадасны хэмжээ бага, салхи ихтэй учир шороон шуургатай өдрийн тоо 90 гаруй байдаг. Жилд орох хур тунадасны хэмжээ 100-150 мм, агаарын дундаж даралт 850-900 гПа, энэ хэмжээ 7 ба 1 сарын дундажтай адил. Агаарын хэмийн олон жилийн дундаж нь +2°С-оос +4°С. Усан сүлжээний мужлалаар Төв Азийн гадагш урсацгүй ай савд хамаарна. Байгалийн бүслүүржилтээр заримдаг цөлийн цөлжүү хээрийн дэд бүсэд хамаарна |
| **Ус зүйн сүлжээ** | Ордын талбай орчмын газрын доорх усны үүсэл, хөдөлгөөн, хуримтлалын ерөнхий зүй тогтлыг тодорхойлох үндсэн хүчин зүйлд геологийн тогтцын онцлог, чулуулгийн литологийн найрлага, тектоник, геоморфологи ба цаг уурын онцлог шинжүүд орно. Тус дүүрэгт байршлын нөхцөл, эргэлт, тэжээгдэл ба горимоос хамааран газрын доорх усыг дараах төрлүүдэд хувааж үзжээ. *Дөрөвдөгчийн хурдасны хөрсний ус* нь аллювийн, делювийн, салхины, пролювийн болон бусад гарлын хурдсанд хаяагүй тархсан. Чулуулгийн усжилт бага, худгуудын ундарга 0.1-0.3 л/с болно. Худаг, булаг нь үндсэн чулуулаг дахь дөрөвдөгчийн хурдсаар хучигдсан хагарлын бүсүүдэд тархсан байдаг. Хөрсний ус нь хур тунадасны ус ба хажуу гадаргаас хотгор руу урсах түр зуурын урсгал усны шингэлтээр тэжээгддэ г. *Нүүрс агуулагч зузаалаг дахь газар доорх ус.* Газрын доорх усаар тэжээгдэх үндсэн талбай нь ордоос хойш ба баруун урагш оршино. Энэ усны үндсэн эх үүсвэр нь хур тунадасны ус юм. Газар доорх усны хөдөлгөөний үндсэн чиглэл хойноос, баруун урагш хотгорын тэнхлэгийн чигт юм. Газар доорх ус хужиртай, эрдсийн хэмжээ 2.3-8.6 г/л, ерөнхий хатуулаг гол төлөв 6.5-18.3 мг.экв/л. Сульфат-хлоридын ба хлорид-сульфатын химийн найрлагатай. |
| **Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг** | Уг төсөл нь бусад аливаа ердийн инженерийн байгууламжийн барилга угсралтын ажилтай адилгүй ч хүрээлэн буй орчны ландшафтанд нөлөөлнө. Цагаан хад орчмын автозамын эвдрэл ихтэй Баян-Овоо сум, томоохон уул уурхайтай Гурвантэс сум байна.Өмнөговь аймгийн нутагт бүртгэсэн байгалийн дээдургамлын ангиллын үндсэн бүлгүүдийн бүтцийг авч үзэхэд шивлээн хүрээний зүйл ургамалгүй, оймын хүрээний 4 зүйл, нүцгэн эртний хүрээний 7 зүйл, бүрхүүл эртний хүрээний 603 зүйл (үүнээс нэг талтан 129 зүйл, хос талтан 474 зүйл) байна. Ургамалаас цайвар бор хөрсөн дээр баглуур, харганатай, бутлаг үетэн зонхилон (хялгана, сайрын хялгана) ургадаг. Тухайн орд орших Цогтцэций сум болон зэргэлдээ сумдын нутаг нь Галбын говийн бог мал, тэмээн сүргийг үндсэн ба тэргүүлэх салбар болгон эрхлэхэд тохиромжтой мал аж ахуйн мужид багтдаг. |
| **Амьтны аймаг** | Төслийн талбайн ой Хөхтөн амьтны аймгаас цоохондой хэвийн тархалттай, мөлхөгчдөөс цоохор хонин гүрвэл элбэг, төмөр гүрвэл цөөвтөр ба шувуудаас монгол хулан жороо хэвийн, хонин тоодог цөөн тоогоор тархсан байдаг.. |

# БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

## 3.1. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Энэ бүлэгт төслөөс байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг нөлөөлөлд өртөх орчноор буюу газрын гадарга, уур амьсгал, агаарын чанар, гадаргын болон гүний ус, хөрсөн бүрхэвч, ургамлын аймаг, амьтны аймаг, түүх соёлын дурсгал, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн иргэдийн нийгмийн байдал, эрүүл мэнд зэрэг чиглэлүүдээр авч үзэн тодорхойлж, тэдгээр нөлөөллийн эрчим, цар хүрээг үнэлэн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг тусгасан болно.

## 3.2. БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг Байгаль Орчин Ногоон Хөгжлийн Сайдын 2014 оны 04 сарын 10-ны өдрийн А/117 дугаар тушаалын 2 дугээр хавсралт, Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх шинэчилсэн аргачлал болон түүнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2017 оны 12 сарын 31-ны өдрийн А/331 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу хийж гүйцэтгэлээ.

Төслийн үйл ажиллагаанаас үүдэх нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах ажлыг зохион байгуулахын тулд нөлөөллийн хэмжээг тодорхойлно. Нөлөөллийн хэмжээг тодорхойлох нь тухайн хүний ойлголтоос ихээхэн хамаардаг тул ихэнх тохиолдолд байгаль орчны бүрэлдэхүүн тус бүрээр дараах шаардлагыг мөрдөх шаардлагатай. Нөлөөллийн хэмжээг 3 хүчин зүйлээр тодорхойлно. Нөлөөлөл тус бүрд дээр дурдсан хүчин зүйл бүр 1, 2, 3 гэсэн үнэлгээ өгөх бөгөөд энэ нь тухайн нөлөөллийн хэмжээ, тархалт, давтамжийг харуулна. Үүнд: Нөлөөллийн хэмжээ, хугацаа, нөлөөлөлд өртөх газар нутаг, нөлөөлөл тохиолдох, давтагдах магадлал.

***Хүснэгт 4. Нөлөөллийг тооцох аргачлал***

| | |
|---|---|
| **Хэмжээ тархалт (M) 1, 2 ба 3** | Нөлөөллийн хэмжээг тодорхойлно. (бага, дунд, их) Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн хугацааг тодорхойлно. (богино, дунд, урт хугацаа) |
| **Хамрах хүрээ (S) 1, 2 ба 3** | Төслийн үйл ажиллагаанаас нөлөөлөлд өртөх газар зүйн байрлал, талбай (тухайн талбай орчимд, арай өргөвтөр талбайд, нэлээд өргөн газар нутгийг хамарсан) |
| **Давтамж/магадлал (F) 1, 2 ба 3** | Дахин давтагдах магадлал ба дахин давтагдах тоо (бага магадлалтай, өндөр магадлалтай, тохиолдол нь тодорхой) |

Болзошгүй нөлөөллийг хэмжээ, хамрах хүрээ, давтамж гурвын үржвэрээр тооцно.

$$M \times S \times F = \text{Болзошгүй нөлөөллийн хэмжээ}$$

Нөлөөллийн хамгийн бага хэмжээ 1 (1x1x1), хамгийн их хэмжээ нь 27 (3x3x3) байна. Нөлөөллийн хэмжээ 6-аас доош байгаа тохиолдолд үл мэдэгдэх

нөлөөлөл гэж үзнэ. Дараах хүснэгтэд хэмжээ, хамрах хүрээ, давтамж гуравт үнэлгээг харгалзуулах журам, нэгдсэн үнэлгээг тооцоолох тухай журмыг харуулсан болно. Хэрвээ тухайн нөлөөлөл хуулийн зохицуулалт хийх шаардлагатай болохоор бол мэдэгдэхүйц нөлөөлөлд тооцогдоно.

***Хүснэгт 5. Байгаль орчинд нөлөөлөх байдлыг тодорхойлох шалгуур***

| Төрөл/үнэлгээ Шалгуур | Төрөл/үнэлгээ Шалгуур | | |
|---|---|---|---|
| **M: Хэмжээ, тархалт** | | | |
| **Түвшин -1** | Түвшин -1 Бага болон богино хугацааны нөлөөлөл - энэ хоёр нөхцөлийг зэрэг хангасан тохиолдолд | | |
| **Түвшин -2** | Дунд зэрэг, эсвэл дунд хугацааны нөлөөлөл - Энэ хоёр нөхцөлийн аль нэгийг хангасан тохиолдолд | | |
| **Түвшин -3** | Томоохон, эсвэл урт хугацааны нөлөөлөл- Энэ хоёр нөхцөлийг аль нэгийг хангасан тохиолдолд | | |
| **Нөлөөллийн түвшин** | | | |
| Бага зэргийн нөлөөлөл | Хэмжээ, тархалтын хувьд бага | Богино хугацааны | Төсөл дууссанаас хойш 6 сарын хугацаа нөхөн сэргээгдэх боломжтой |
| Дунд зэргийн нөлөөлөл | Хэмжээ, тархалтын хувьд дунд зэрэг | Дунд хугацааны | Төсөл дууссанаас хойш 6 сараас 2 жилийн хугацаанд нөхөн сэргээгдэх боломжтой. |
| Томоохон нөлөөлөл | Хэмжээ, тархалтын хувьд их | Урт хугацааны | Төсөл дууссанаас хойш 2 ба түүнээс жилийн хугацаанд дараа нөхөн сэргээгдэх боломжтой |
| **S: хамрах хүрээ буюу газарзүйн тархалт** | | | |
| **Үнэлгээ= 1** | Нөлөөлөх талбай: зөвхөн төслийн талбайн хүрээнд | | |
| **Үнэлгээ =2** | Нөлөөлөх талбай: төслийн талбайгаас гадагш 500м-ийн радиуст | | |
| **Үнэлгээ =3** | Нөлөөлөх талбайн: 500м-ийн радиусаас цааш талбайг хамарсан | | |
| **F: Давтамж буюу магадлал** | | | |
| **Үнэлгээ= 1** | Бага магадлалтай- Санал болгож буй төсөлтэй ижил төслүүдийн хувьд үүсэж байсан, энэ төслийн хувьд бараг тохиолдох боломжгүй | | |
| **Үнэлгээ =2** | Дунд зэргийн магадлалтай - Энэ төслийн хувьд тохиолдох боломжтой | | |
| **Үнэлгээ =3** | Өндөр магадлалтай - Энэ төслийн хувьд бараг л тохиолдоно | | |
| Нийт түвшин=M x S x F | Үнэлгээ | Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн хэмжээ | |
| **Нөлөөллийн түвшин бага** | <6 | Бага - Тийм ч анхаарал татахуйц биш | |
| **Нөлөөллийн түвшин дунд** | 6-18 | Дунд - урьдчилан сэргийлж, нөлөөллийг бууруулж зохицуулах боломжтой | |
| **Нөлөөллийн түвшин өндөр** | >18 | Их буюу өндөр - урьдчилан сэргийлж, нөлөөллийг бууруулж зохицуулах боломжтой | |
| **Бууруулж болохуйц нөлөөлөл: Нөлөөлөл нь их боловч тодорхой аргыг хэрэглэснээр нөлөөллийн түвшнийг бууруулах боломжтой.** | | | |
| **Үр дүнтэй (эерэг нөлөөлөл): Нөлөөлөл нь их боловч байгаль орчин, хүний хэрэглээ, хүний үнэ цэнийг сайжруулж чадна** | | | |

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учирч болзошгүй нөлөөллийг газрын гадарга, уур амьсгал, агаарын чанар, дуу чимээ, усан орчин, хөрс, ургамал үзүүлэх байдлаар нь үнэлж, үр дүнг тодорхойлов.

***Хүснэгт 6. Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ***

| Байгаль орчны хүчин зүйлс | Эрчим | | Тайлбар |
|---|---|---|---|
| | M x S x F | Нөлөөллийн үнэлгээ, эрчим | |
| **Агаарын чанарт** | 1x2x2 | Бага - Тийм ч анхаарал татахуйц биш | • Төслийн үйл ажиллагаа, засвар үйлчилгээнд явах машинууд олон салаа зам гаргаж газрын гадарга талхлах, тэдгээрийн хөдөлгөөнөөс агаарт тоос дэгдэх |
| **Дуу чимээнд үзүүлэх нөлөө** | 1x2x2 | Бага - Тийм ч анхаарал татахуйц биш | • Төслийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөс дуу шуугиан үүсэж, орчинд тархах |
| **Газрын гадаргад үзүүлэх нөлөө** | 1x1x3 | Бага - Тийм ч анхаарал татахуйц биш | • Барилга угсралтын үйл ажиллагаа, машин техникийн хөдөлгөөнөөр газрын гадаргад нөлөө үзүүлнэ. |
| **Хөрсөнд үзүүлэх нөлөө** | 2x2x2 | Дунд - урьдчилан сэргийлж, нөлөөллийг бууруулж зохицуулах боломжтой | • Машин техникийн хөдөлгөөнөөр олон салаа зам үүсэх, газрын гадарга, хөрсөн бүрхэвчид элэгдэл, эвдрэл үүсэх<br>• Түүхий эдийн тээвэрлэлттэй холбоотойгоор хөрсөн бүрхэвч элэгдэлд өртөх, физик шинж чанар өөрчлөгдөх |
| **Ургамлын бүрхэвчид үзүүлэх нөлөө** | 2x2x2 | Дунд - урьдчилан сэргийлж, нөлөөллийг бууруулж зохицуулах боломжтой | • Төслийн барилга байгууламж, тулгуур шон угсрах, шинэчлэх үйл ажиллагаанд ойр ормын ургамлан нөмрөг талхлагдах, устаж үгүй болох<br>• Төслийн бүхий л үйл явц, түүний хог хаягдал, зам зэрэг үйл ажиллагаанаас буй болох тоосжилт нь ургамал нөмрөг дээр бууж хуримтлагдах |
| **Усан орчин** | 1x1x2 | Бага - Тийм ч анхаарал татахуйц биш | • Авто засварын газар болон авто машинаас шатахуун болон шатах тослох материал асгаран хөрсөн бүрхэвчээр дамжин гадаргын болон газрын доорх усанд нэвчих бохирдол үүсэх<br>• Төслийн үйл ажиллагаанаас үүсэх хатуу хог хаягдал зэргийн үлдэгдэл угаадан хөрс, газрын хэвлийг бохирдуулах улмаар гүний усыг бохирдуулах |
| **Амьтны аймаг** | 1x1x2 | Бага - Тийм ч анхаарал татахуйц биш | • Засвар үйлчилгээ, барилга угсралтын үед ажиллах тээврийн хэрэгсэл, техникүүдийн дуу чимээнээс амьтад үргэн дайжих<br>• Зэрлэг амьтдын амьдрах таатай орчинд сөргөөр нөлөөлөх, нүүдлийн замд саад хийх |

## 3.3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

*Хүснэгт 7. Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ*

| Үзүүлэлт | Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх |
|---|---|
| **Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ** | ✓ Төслийн технологийн үйл ажиллагаа нь орчин үеийн тоосжилтыг багасгаж байгаль орчинд ээлтэй байхаар шийдэгдсэнн бөгөөд агаарт CO2, Nox төрлийн хийг багасгаж SO2, төрөл бүрийн хорт тоосонцоруудыг агаарт цацагдахаас хамгаална. Гэсэн хэдий ч тухайн жилийн БОМТ-н БОХТ, БОХШХ-т тусгасан үйл ажиллагааг хэрэгжүүлж, тоос болон бусад хийн хэмжилтийг хийж, тухайн орчны агаарын бохирдолтыг хянаж байх. Төслийн зүгээс үйлдвэрийн талбайд нүүрс ачих, буулгах, бутлах, ялгарах тоосыг 10 метр өндөр хашаа барьж бууруулах арга хэмжээг авах.<br>✓ Төслийн бүхий л үйл ажиллагааны явцад тоосжилтыг хянах бууруулах үр ашигтай бөгөөд практик ач холбогдолтой үйл ажиллагааны журмыг боловсруулан мөрдөх,<br>✓ Тээврийн хэрэгслийн янданд шүүлтүүр тавих, төслийн үйл ажиллагаанд ашиглах машины техникийн оношилгоо, тохиргоо, үйлчилгээг тогтмол хийж, ашиглалтын нөхцөлийг сайжруулах замаар агаарын бохирдлыг багасгах арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай<br>✓ Хатуу хог хаягдлыг тогтмол ачуулж, төслийн талбайд удаан хадгалахгүй байх<br>✓ Зориулалтын замаас гадуур өөр зам гаргахгүй байх тал дээр анхаарах<br>✓ Хэт халалт, агаарын бохирдол тоосжилтыг бага байлгахын тулд ногоон байгууламжийн талбайг нэмэгдүүлэх |
| **Дуу чимээнээс үзүүлэх нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ** | ✓ Авто машины дуут дохиог гэнэтийн ослоос сэргийлэхээс бусад үед өгөхгүй байх, оройны 10 цагаас хойш ямар нэгэн олныг хамарсан дуу чимээ гаргуулахгүй байх ба ажлын бус цагаар тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг багасгах<br>✓ Шуугианы түвшнийг зохицуулж хянаж байх, чимээ ихтэй тоног төхөөрөмж ашиглахгүй байх,<br>✓ Ашиглахгүй үед тоног төхөөрөмжөө заавал унтрааж байх. |
| **Усан орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ** | ✓ Ундны усны хадгалалт цэвэр, эрсдэлгүй байгааг шалгаж баталгаажуулах.<br>✓ Хатуу/аюултай хог хаягдлын байгаль орчинд ээлтэй болон бусад менежмент хэрэгжүүлэх |
| **Газрын гадаргад үзүүлэх нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ** | ✓ Замын нэгдсэн сүлжээг бий болгох, цаашид онц шаардлагагүйгээр шинээр зам бий болгохгүй байх,<br>✓ Ойр орчмын газартаа нөхөн сэргээлт хийх |
| **Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ** | ✓ Хатуу хучилтгүй замаар зорчих үед автомашины хурдыг хязгаарлах,<br>✓ Салбар хооронд болон шугам сүлжээний засвар үйлчилгээний замын сүлжээг сайжруулах,<br>✓ Замын нэгдсэн сүлжээг бий болгох, цаашид онц шаардлагагүйгээр шинээр зам бий болгохгүй байх,<br>✓ Хөрс бохирдуулагч материалуудын хяналт, зохицуулалтыг сайжруулах,<br>✓ Тээврийн хэрэгслээс шатах, тослох материал асгарахаас сэргийлэх. Асгарсан тохиолдолд түргэн шуурхай сэргийлэх арга хэмжээ авах.<br>✓ Машин механизмыг зориулалтын талбайд байрлуулах, засвар үйлчилгээг мөн зориулалтын талбайд хийх,<br>✓ Түлш, тосолгооны материал, химийн бодис агуулах сав гэх мэт болзошгүй эх үүсвэрүүдээс асгаралт үүсэхээс сэргийлсэн хамгаалалтын суурь хийх |
| **Ургамлын нөмрөгт үзүүлэх нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ** | ✓ Төслийн талбайн 10 -аас багагүй хувьд ургамлан бүрхэвчийн нягтралыг даруй нэмэгдүүлэх тухайн орчны уур амьсгал, экологийн нөхцөлд зохицсон модлог ургамал |

| | |
|---|---|
| | тарих<br>✓ Тоосжилт нь ургамлын навчны амсрыг бөглөх, улмаар фотосинтезийн явцыг бууруулах, ургамлын ургалтыг доройтуулах сөрөг нөлөөтэй юм. Иймд хатуу хучилтгүй замд автомашины хурдыг хязгаарлах, замын сүлжээг сайжруулах, тоосжилтыг бууруулах усалгааг хийх,<br>✓ Замын нэгдсэн сүлжээг нэн даруй бий болгох, цаашид онц шаардлагагүйгээр шинээр зам бий болгохгүй байх,<br>✓ Хөрс бохирдуулагч материалуудын хяналт зохицуулалтыг сайжруулах,<br>✓ Засвар үйлчилгээ, барилга угсралт болон цахилгаан дамжуулах шугамын ашиглалтын үед хэрэглэгдэх машин, механизмыг тогтмол үзлэг оношилгоонд хамруулах, ШТМ-ын асгаралт үүсгэж байгаа эсэхэд хяналт тавих,<br>✓ Машин механизмыг зориулалтын талбайд байрлуулах, засвар үйлчилгээг мөн зориулалтын байранд хийх<br>✓ Түлш, тосолгооны материал, химийн бодис агуулах сав зэрэг асгаралт үүсгэж болзошгүй эх үүсвэрүүдээс асгаралт үүсгэхээс сэргийлсэн хамгаалалтын суурь хийх |
| **Нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арилгах арга хэмжээ** | ✓ Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, өндөр давтамж (85 дБА-аас дээш)-тай дуу шуугиан үүсгэх ажлыг өдрийн цагаар гүйцэтгэх,<br>✓ Шөнийн цагаар 22:00 – 07:00 цагийн хооронд 45 дБА-аас өндөр давтамжтай дуу шуугиан үүсгэх ажлыг аль болох гүйцэтгэхгүй байх,<br>✓ Тээврийн хэрэгслүүд зорчих авто замын маршрутыг барилгын ажил эхлэхээс өмнө гаргах,<br>✓ Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан хог хаягдлын нэгдсэн цэгт хаях. Ахуйн шингэн хаягдал бохирын системд зайлуулах. Саарал усыг бага оврын цэвэршүүлэх станц барьж цэвэршүүлэн ногоон байгууламж, тээврийн зам, үйлдвэрийн талбайн усалгаа зэрэгт ашиглах<br>✓ Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж ажиллах,<br>✓ Ажиллах хүчийг төсөл хэрэгжих орон нутгийн иргэдээс авч ажиллуулах нь тэдний амьжиргаа, нийгэм эдийн засгийн хөгжилд эерэг нөлөөлнө. Иргэдээс төслийн үйл ажиллагаатай холбоотой санал, хүсэлтийг хүлээн авч зохих арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллах зэрэг болно. |

# БҮЛЭГ 4. ТЖБОМТ-НИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

## 4.1. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮНДЭСЛЭЛ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн байдлын үнэлгээний тухайн хуулийн шинэчилсэн найруулгад зааснаар аливаа төслийг хэрэгжүүлэхдээ байгаль орчны менежментийн төлөвлөгөөг захиргааны төв байгууллагаар батлагдах төсөл хэрэгжүүлэх, дараа дараагийн жилүүдэд үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Байгаль орчинд нөлөөлөх Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнд үндэслэн боловсруулж, ерөнхий үнэлгээг хийсэн байгууллагаар хянуулах, батлагдсаны дараа хэрэгжилтийг хангаж ажиллах үүргийг тухайн төсөл хэрэгжүүлэгч хүлээхээр заасан.

Бид бүхэн 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хууль, Монгол Улсын Засгийн газрын 2013.11.16-ны өдрийн 374 дүгээр тогтоолоор баталсан Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам, БОНХС-ын 2014.04.10-ны өдрийн А-117 тоот тушаалын 2 дугаар хавсралт “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний аргачлал”, БОАЖСайдын 2019 оны А/618 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, тушаалуудыг үндэслэн боловсруулав.

## 4.2. ТЖБОМТ-НИЙ ЗОРИЛГО, АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ҮР ДҮН

***Ажлын зорилго:*** Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төслийн талбай, түүний орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм. Энэхүү төлөвлөгөөг батлуулан, хэрэгжүүлж ажилласнаар доорх зорилтуудыг хангана. Үүнд:

a) Ажиллагсад бүх байгаль орчныг хамгаалах асуудалтай холбоотой үүрэг хариуцлагаа бүрэн ойлгосон байхын зэрэгцээ тэдэнд биелүүлэхэд нь туслах бэлтгэл сургалт, ур чадвартай мэргэжилтэнтэй болсон байна.

b) Байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, эрсдэлийг урьдчилан тооцож, байгальд шууд болон шууд бус хэлбэрээр үзүүлэх нөлөөллийг бууруулах, орчны төлөв байдлыг сайжруулах, хэвийн нөхцөлийг хадгалж хамгаална.

c) Орон нутгийн удирдлага, хяналтын байгууллага, иргэдтэй байгаль орчныг хамгаалах асуудлаар зөвлөлдөж, тэдний санал, хүсэлтийг хүлээн авч, хамтран ажиллана Байгаль орчны асуудлаарх төрийн захиргаанаас өгсөн санал зөвлөмжүүдийг хэрэгжүүлж ажиллана.

Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь тухайн төслийн БОМТ-тэй танилцан баталж, төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх зөвшөөрлийг олгох ба жил бүрийн хэрэгжилтийн тайланг хянаж,

дараа жилийн төлөвлөгөөг батлах замаар уг төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хянана. Мөн БОМТ-ний хэрэгжилтэд тухайн орон нутгийн байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатны засаг дарга, БОАЖГ болон байгаль орчны төрийн бус байгууллага хяналт тавих эрхтэй ба тэдгээрт холбогдох мэдээлэл ил тод болгох, тодорхой хуваарийн дагуу хяналт хийх боломжийг бүрдүүлэх нь төсөл хэрэгжүүлэгчийн үүрэг болно.

“Саусгоби даймонд” ХХК-ийн “Нүүрсийг хуурай аргаар баяжуулах үйлдвэр” төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэм-эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл болон эрсдлийн үнэлгээний үр дүнгээс үзэхэд төслийн үйл ажиллагаанд технологийн болон байгаль орчны дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь үүсч болох эрсдэл, сөрөг үр дагавараас урьдчилан сэргийлэх нөхцлийг бүрдүүлнэ. Эдгээр зөвлөмжийг авч хэрэгжүүлэхдээ энэхүү байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн хууль эрх зүйн бүлэгт орсон хууль, дүрэм журам, стандарт болон Олон улсын конвецийн холбогдох заалтыг мөрдлөг болгон ажиллах хэрэгтэй. Төслийн 2024-202 он хүртлэх 5 жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчин, хүний эрүүл мэндэд нөлөөлөх сөрөг нөлөөллөөс урьдчилсан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, эрсдлийн менежментийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө багтсан бөгөөд БОМТ-нд тусгагдсан ажлуудыг төсөл хэрэгжүүлэгч компаний удирдлага хариуцан гүйцэтгэнэ.

“Саусгоби даймонд” ХХК-ийн “Нүүрсийг хуурай аргаар баяжуулах үйлдвэр” төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэм-эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл болон эрсдлийн үнэлгээний үр дүнгээс үзэхэд төслийн үйл ажиллагаанд технологийн болон байгаль орчны дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь үүсч болох эрсдэл, сөрөг үр дагавараас урьдчилан сэргийлэх нөхцлийг бүрдүүлнэ. Эдгээр зөвлөмжийг авч хэрэгжүүлэхдээ энэхүү байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн хууль эрх зүйн бүлэгт орсон хууль, дүрэм журам, стандарт болон Олон улсын конвецийн холбогдох заалтыг мөрдлөг болгон ажиллах хэрэгтэй. Төслийн 2025-2026 он хүртлэх 1 жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчин, хүний эрүүл мэндэд нөлөөлөх сөрөг нөлөөллөөс урьдчилсан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, эрсдлийн менежментийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө багтсан бөгөөд БОМТ-нд тусгагдсан ажлуудыг төсөл хэрэгжүүлэгч компаний удирдлага хариуцан гүйцэтгэнэ.

Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний зөвлөмж: Баяжуулах үйлдвэрийн төслөөс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл дунд байна. Иймд төслийн байгаль орчныг хамгаалах арга хэмжээг огтхон ч орхигдуулж болохгүй төдийгүй байгаль орчныг хамгаалах зардлыг хүрэлцээтэй төлөвлөж байгаль орчинг хамгаалах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай бөгөөд эдгээр нь тухайн төслөөс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, байж болох хамгийн бага түвшинд аваачих ач холбогдолтой юм. Мөн нутгийн иргэдийн санал хүсэлтийг сонсох, иргэдтэй хамтарч байгаль

хамгаалах талаарх асуудлыг шийдвэрлэх санал, хэлэлцүүлэг зохиох, төслийн үйл ажиллагаатай холбоотой иргэдиийн санал, гомдлыг сонсох, тэдэнд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх зэргээр орон нутгийн иргэдтэй хамтарч ажиллах, иргэдийг ажлын байраар хангах, тэднийг дэмжих үйл ажиллагааг байнга хэрэгжүүлж байх нь зүйтэй юм.

1. Ногоон байгууламж байгуулах зөвлөмж /Хайлас, бут тарьж, ургуулах зөвлөмж/
2. Хаягдал ус цэвэршүүлэх зөвлөмж
3. Хог хаягдлыг ялган хаях цэг байгуулах
4. Борооны усыг хуримтлуулан ногоон байгууламжийг усалгаажуулах зөвлөмж
5. Усалгаанд дуслын системийг ашиглах
6. Галын хор байрлуулах зөвлөмж
7. Аянга хамгаалагч, газардуулгын систем байрлуулах зөвлөмж зэргийг тусгалаа.

***Хүснэгт 8. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал 1 жилээр***

| Д/д | Хөрөнгийн зориулалт | Хэмжих нэгж | Нийт зардал |
|---|---|---|---|
| 1 | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө/ агаар, хөрс, ус, ургамал, ан амьтан/ | Мян.төг | 3 670.0 |
| 2 | Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө | Мян.төг | 75.0 |
| 3 | Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө | Мян.төг | - |
| 4 | Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө | Мян.төг | - |
| 5 | Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө | Мян.төг | 700.0 |
| 6 | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө | Мян.төг | 2 360.0 |
| 7 | Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө | Мян.төг | 940.0 |
| 8 | БОМТ -г орон нутагт тайлагнах төлөвлөгөө | Мян.төг | 210.0 |
| 9 | Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр | Мян.төг | 186.0 |
| | **Дүн** | | **8 141.0** |

# БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагааны явцад үүсэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүнээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, зарцуулах төсөв, баримтлах эрх зүйн баримт бичиг зэргийг тодорхойлон доорх хүснэгтэд тусгав.

***Хүснэгт 9. Байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний зардал***

| Гол ба болзошгүй сөрөг нөлөө | Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Тоо хэмжээ | Нэгж зардал (мян.төг) | Нийт зардал (мян.төг) | Хэрэгжүүлэгч | Хамтран хэрэгжүүлэгч | Баримтлах стандарт, аргачлал |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ** | | | | | | | | |
| Төслийн үйл ажиллагаанаас | Баяжуулах үйлдвэрийн тоос баригчийг сайжруулах Төслийн үйл ажиллагаанд ашиглагдах тээврийн хэрэгслүүдийг үзлэг оношилгоонд хамруулах | Тээврийн 10 автомашин | 2 удаа | | | "Саусгоби даймонд" ХХК | Мэргэжлийн байгууллага, компани | Агаарын тухай хууль, MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4990:2015 Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага MNS 5916:2008 Байгаль орчин, Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5918:2008 Байгаль орчин. Эвдэрсэн газрыг ургамалжуулах. |
| | Төслийн талбайд ногоон байгууламж байгуулах, тарималжуулалтын ажлыг хийж гүйцэтгэх | Төслийн талбайд | 1 га гаас багагүй талбайд | - | | | | |
| Тээврийн хэрэгслээс ялгарах хийн хаягдал Тоосжилт | Төслийн дулаан хангамжийг цахилгаан халаагуураар шийдэх | Бүх барилга байгууламжид | | - | | "Саусгоби даймонд" ХХК | Мэргэжлийн байгууллага, компани | |
| | Орчны агаараас сорьц дээж авч, мэргэжлийн байгууллагаар шинжилгээ хийлгэж, түвшинг тодорхойлуулан, заавар зөвлөмж авч ажиллах | Агаарын чанар | Жилд 2 оос доошгүй удаа | ОХШХ -т тусгагдсан | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Салхинаас хамгаалах 10 м өндөр хашааны хэвийн ажиллагаанд хяналт тавьж ажиллах, засвар үйлчилгээг тогмол хийж байх | Салхинаас хамгаалах 10 м өндөр хашаа | 240.0 | | “Саусгоби даймонд” ХХК | “Саусгоби даймонд” ХХК | Техникийн ерөнхий шаардлага MNS 6260:2011 Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих, арчлах MNS 5973:2009 Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээг төлөвлөхөд ногоон байгууламжийн ойртох зай, хэмжээ |
| **Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ** | | | | | | | |
| Ус хэмнэх | Ахуйн бохир ус цэвэршүүлэх байгууламж суурилуулах | 2025 онд | 3 000.0 | | “Саусгоби даймонд” ХХК | “Мон казе” ХХК | |
| Усны нөөцийн хомсдол үүсэхээс сэргийлэх | Хаягдал пластик сав ашиглан ногоон байгууламж услах дуслын усалгааны систем хийх | Төслийн талбайд | Ногоон байгууламжийн хэмжээнээс хамаарна. | | “Саусгоби даймонд” ХХК | | Усны тухай хууль “Хот суурин газарт ундны ус түгээх цэгийн үйлчилгээ.” ерөнхий шаардлага MNS 5775:2007 “Ундны ус эрүүл ахуйн шаардлага, түүнд тавигдах хяналт” MNS 0900:2018 |
| Усны нөөц, хэрэглээ | Усыг хэмнэх төхөөрөмжийг үйлчилгээндээ ашиглах /ус хэмнэгч хошуу/ | Ариун цэврийн өрөө, гал тогооны угаалтуурт | 80.0 | 80.0 | Төсөл хэрэгжүүлэгч | Нийлүүлэгч байгууллага | |
| Ус хэмнэх | Борооны ус хуримтлуулах төхөөрөмж суурилуулах | Төслийн талбайд | Дотоод төлөвлөлтөөр | | Төсөл хэрэгжүүлэгч | | |
| **Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, газрын гадаргад үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ** | | | | | | | |
| Хөрсөнд шатах тослох | Төслийн талбай доторх, авто зам, явган хүний шороон замыг хатуу хучилттай | Төслийн талбайд | Үйл ажиллагааны зардалд тусгах | | Төсөл хэрэгжүүлэгч | | Автозогсоол. Ангилал ба ерөнхий шаардлага MNS |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| материал алдагдах, хөрс бохирдох, тоосжилт | болгох | | | | 5342:2007 Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага MNS 4597:2014 Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2011 оны 216 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт |
| Олон салаа зам гарах өөрчлөгдөх | Тээврийн хэрэгслийг тогтсон замтай болгож, замын тэмдэг тэмдэгжүүлэлтийг стандартын дагуу хийж байршуулах | Ойр орчмын хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, агаар орчин 35 ш | 350.0 | Төсөл хэрэгжүүлэгч | |
| Ургамлан нөмрөг талхлагдах, хөрсөн бүрхэвч бохирдох | Төсөл хэрэгжих талбай, хашаанаас гадна хог хаягдал хаяхгүй, газрын гадарга, хөрсийг эвдэхгүй, хөндөхгүй байх арга хэмжээг хэрэгжүүлж байх | Ойр орчмын хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг Тогтмол | Үйл ажиллагааны зардалд тусгагдсан | “Саусгоби даймонд” ХХК | |
| **Нийт зардал** | | | **3 670.0** | | |

# БҮЛЭГ 6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4-ийн дагуу эзэмшил газрын 10 хувиас доошгүй талбайд зохих журмын дагуу зүлэгжүүлж мод тариалах шаардлагыг үүрэгжүүлж өгсөн байдаг. Иймд эзэмшил газрын 10-аас багагүй хувийг тохижилт, агаарын бохирдлыг бууруулах, ургамалжуулах зэрэг зорилгоор моджуулах арга хэмжээг зайлшгүй хийх шаардлагатай юм. Баяжуулах үйлдвэрийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан моджуулах ажлыг БОННҮ-ний тайлан тусгасан зөвлөмжийн дагуу тарих шаардлагатай. Ер нь газрын нөхөн сэргээлт гэдэг нь “эвдэрсэн газрын аж ахуйн үнэ цэнэ, бүтээмжийг нь сэргээх, тэрчлэн хүрээлэн буй орчны нөхцөлийг нийгмийн ашиг сонирхолд нийцүүлэн сайжруулахад чиглэсэн цогц арга хэмжээ” юм. Жил бүр мод тарих ажлыг зохион байгуулж, өмнө тарьсныгаа арчлах, амьдраагүй хэсэгт нөхөн тарилт хийх зэргээр уламжлалт тогтсон өдөртэй болсон байна

*Хүснэгт 10. Орчны тохижилт, ногоон байгууламжийн төлөвлөгөө*

| № | Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт | Нөхөн сэргээлтийн арга хэмжээ | Арга хэмжээний цар хүрээ | Хэмжих нэгж | Тоо хэмжээ) | Нэгжийн зардал, төг | Нийт зардал мян.төг | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Мод, бутны арчлалт хамгаалалт | Ургаагүй мод бутыг нөхөн тарих арчлалт хамгаалалт хийх | Төслийн талбай | Удаа | 2 | 25.0 | 50.0 | 2025 онд 10 сард |
| Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн нийт зардал, мян.төг | | | | | | 75.0 | | |

# БҮЛЭГ 7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Саусгоби даймонд” ХХК нь Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын нутаг дэвсгэрт тус сумын Засаг даргын 2021 оны 02 сарын 23-ны өдрийн А/13 тоот шийдвэрээр 00009710 тоот гэрчилгээ бүхий 5 га талбайг 15 жилийн хугацаатай Үйлдвэрлэл үйлчилгээ зориулалтаар эзэмшихээр эрх авсан. Төслийг хэрэгжүүлэх хугацаанд болон цаашид ойролцоох аж ахуйн нэгж, иргэдэд нүүлгэн шилжүүлэх шаардлага өгөөгүй учир нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ өнөөгийн төслийн хүчин чадал, техник эдийн засгийн үндэслэлийн үед гарахгүй.

# БҮЛЭГ 8. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбай болон түүний орчмын нутагт нь түүх соёлын дурсгалд тооцож болохуйц газар болон археологийн болон палентлогийн олдвор одоогоор тохиолдоогүй. Цаашид үйл ажиллагааны явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрсэн үед “Монгол Улсын Үндсэн хууль” -ийн I бүлгийн 7-р зүйлд “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв

төрийн хамгаалалтад байна” гэж заасны дагуу түүх, соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж хамгаалах, сурталчлах, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулахтай холбоотой үүрэг хариуцлагаа мөрдөж ажиллах нь зүйтэй. Соёлын ба үнэт өв зүйлсийг илрүүлж, тэр нь төслийн үйл ажиллагаанд эрсдэхээр байвал орон нутгийн засаг даргаас энэ үйл ажиллагааг даруй зогсоохыг шаардах, боломжтой бол эдгээр газруудыг аль болох зохистойгоор хамгаалахыг хуульд заасан байдаг. Боловсрол, Соёл, ШУ-ны ямны тусгай зөвшөөрөлгүйгээр зөөж шилжүүлэх боломжгүй соёлын ба үнэт дурсгалын өвийг малтах, зөөх, эвдэхийг хуулиар хориглосон.

***Хүснэгт 11. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө***

| Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв | Хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний цар хэмжээ | Тоо хэмжээ | Нэгжийн зардал мян. төг | Нийт зардал мян. төг | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|
| Төслийн үйл ажиллагаагаар түүх, соёлын өвд үзүүлэх шууд сөрөг нөлөө байхгүй ч болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх шаардлагатай | Соёлын өвийг хамгаалах тухай МУ-ын хуулийн дагуу газрын хэвлийг ашиглах явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрвэл ажлаа зогсоож энэ тухай аймаг, сумын засаг дарга, цагдаа болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад даруй мэдэгдэх | 2025 | - | Бүтээн байгуулалт, үйл ажиллагаанд нэмэлтээр тусгах | Тухайн үед нь шийдэх | | Соёлын өвийг хамгаалах тухай хууль |

# БҮЛЭГ 9. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагаанд ахуйн угаалгын (саван, шампунь, угаалгын нунтаг) бодисоос өөр химийн болон цацраг идэвхт бодис хэрэглэгдэхгүй. Тиймээс ахуйн угаалгын бодисоо зориулалтын газар хадгалж хог хаягдлыг зохих журмын дагуу зайлуулах шаардлагатай. Осол эрсдэлээс хамгаалах ажлын ихэнх нь төслийн үйл ажиллагааны явцад хөдөлмөрийн сахилга бат, хариуцлагын тогтолцоогоор шийдвэрлэгдэх боломжтой бөгөөд цаг уурын эрсдэлтэй нөхцөлөөс үүсэх гэнэтийн осол, цаашлаад зэрлэг ан амьтдын ослоос урьдчилан сэргийлэх ажилд холбогдох зардал нь төслийн үйл ажиллагааны зардлын санхүүжилтийн хүрээнд шийдвэрлэгдэх боломжтой юм.

***Хүснэгт12. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө***

| Болзошгүй аюул, осол сөрөг нөлөөлөл | Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Нэгжийн өртөг /мян.төг/ | Нийт зардал /мян.төгрөг/ | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах стандарт, аргачлал | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Галын болон байгалийн аюул гамшигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах | Үйлдвэрийн техник, тоног төхөөрөмж технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах | Барилга байгууламж техник тоног төхөөрөмжид | Үйл ажиллагааны зардалд | | Өдөр бүр, тогтмол / байгаль орчны мэргэжилтэн хариуцна/ | Гамшгаас хамгаалах тухай хууль, 27.1 | |
| | Галын болон байгалийн аюул гамшигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах | Нийт ажиллах хугацаанд Бүх ажилчдад | 500.0 | 500.0 | Сургалтыг улирал бүрт 1 удаа | | |
| | Осол эрсдэл үүссэн үед устгах арга хэмжээний | Үйл ажиллагааны турш | 200.0 | 200.0 | Жил бүр | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төлөвлөгөөтэй байх | | | | | | |
| | Ажилчдыг ажлын хувцас, хамгаалалтын тусгай хэрэгслээр (хөвөн даавуун материалаар хийсэн хувцас, резинэн хормогч, резинэн гутал, резинэн бээлий, хамгаалалтын нүдний шил, маск) хангах | | ХХАЗардал | - | Жил бүр | | |
| | Хүний эрүүл мэндэд үзүүлэх эрсдлийг нарийвчлан мэргэжлийн байгууллагаар тогтоолгох | Төслийн нийт хугацаанд | УАЗардалд | | Жил бүр | | |
| **Нийт дүн 2025 онд** | | | **700.0** | | | | |

# БҮЛЭГ 10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хог хаягдлын менежмент гэдэг нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд хог хаягдлаас үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор хог хаягдлын эх үүсвэрийг бууруулах, ангилан ялгах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, устгах бүхий л процессыг хянаж сайжруулах зохион байгуулалтын арга хэмжээ юм.

Төсөл хэрэгжүүлэгч нь хог хаягдлын менежментийн хүрээнд цаашдын авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх, хог хаягдлыг газар дээр нь ангилан ялгах нөхцөл бололцоог хангаж ажиллах үүрэгтэй.

Эзэмшил газрынхаа ойр орчны цэвэрлэгээг тогтмол хийх, үйл ажиллагааны явцад үүсэх хог хаягдлыг тогтоосон цэгт хуримтлуулж тогтмол хугацаанд зайлуулах, ангилан ялгаж дахин ашиглах боломжтой хаягдлыг ашиглах, аливаа зүйлээр бохирдсон хог хаягдлыг саармагжуулах, галын аюулаас хамгаалах, хадгалалт хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хүрээнд төслийн үйл ажиллагаанаас үүсэх хог хог хаягдлын сөрөг нөлөөллийг буруулах, багасгах хянах үүднээс авч хэрэгжүүлэх арга хэмжээг доорх хүснэгтэд боловсруулж оруулсан болно.

Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж хадгалахдаа хогийн сав болон хогийн цэгийг өнгөөр ялгаж зургаар тэмдэгжүүлснээр хуурай хог хаягдлыг стандартын дагуу ачиж, тээвэрлэх хадгалах нөхцөл бүрдэхээс гадна байгаль орчинд сөрөг нөлөөгүй бохирдолгүй амьдрах нөхцөл бололцоо бий болох юм.

Хатуу хог хаягдлаа ялган ангилсны ач холбогдол:

- Цаас, шил, мод, яс, хуванцар, металл, органик гаралтай хаягдлыг эргүүлэн ашиглах, дахин боловсруулах боломж бий болно.
- Орчныг бохирдуулах, устгал хийх хогны хэмжээ эрс багасна.
- Хог хаягдлыг байгаль орчинд халгүйгээр ачиж тээвэрлэх боломж бүрдэнэ.
- Хүн амын аюулгүй, цэвэр, эрүүл орчинд ажиллах, амрах нөхцөл бүрдэнэ.
- Амьтан, ургамал, хөрс, усанд үзүүлэх сөрөг нөлөөлөл багасах зэрэг олон талын ач холбогдолтой юм.

***Хүснэгт 13.* хог хаягдлын менежментийн төлөвлөгөө**

| № | Хог хаягдлын ангилал | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөлийн хамрах хүрээ | Хэмжих нэгж | Нэгжийн зардал, мян.төг | Тоо хэмжээ | Нийт зардал, мян.төг | Хэрэгжүүлэх хугацаа | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Ахуйн | Ажилчдын байранд хогийн сав байрлуулж, хогийг ангилан ялгуулж байх Мэдээлэл, сурталчилгаа хийж, тэмдэгжүүлэх Хаягдал зайлуулах гэрээг эрх бүхий этгээдтэй хийх | Төслийн үйл ажиллагаа | ш | 100.0 | 1 | 100.0 | 2025 онд | Хог хаягдлын тухай хууль, Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага Хог хаягдлын улсын мэдээллийн сангийн тогтолцоо, бүрдэл болон мэдээлэл төвлөрүүлэх журам MNS 5924:2015 Нүхэн жорлон, угаадасны нүх. |
| 2 | Үйлдвэрийн | | | - | | | | | |
| 3 | Аюултай | | Аюултай хог хаягдал үүсэх эх үүсвэүүд | тн | - | - | - | 2025 онд | |
| 4 | Түр хадгалах | Хог хаягдлыг ангилан ялгах, түр хадгалах төвлөрсөн цэгийг битүүмжлэн байгуулах | Талбайн хэмжээнд | ш | 2 000.0 | 1 | 2 000.0 | 2025 онд | |
| 5 | Ариутгал халдваргүйжүүлэлт хийх | Хатуу, шингэн хог хаягдлын цэгүүдэд ариутгал, халдваргүйжүүлэлт хийх | Хог хаягдлын цэг | Удаа | 20.0 | Сард 1 удаа | 3 сар*20.0=1 60.0 | 2025 онд | |
| 6 | | | Нүхэн жорлон | 1 ш | 2 500.0 20.0 | Зөвлөмжид өгсөн дагуу шинээр | 2 500.0 3 сар*20.0*1 жил= 60.0 | 2025 онд | |

| | | | | | | барих | | | Техникийн шаардлага |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | Бага оврын цэвэрлэх байгууламж | Ахуйн болон зарим үйлдвэрийн хаягдал бохирын усыг цэвэршүүлэх | Талбайн хэмжээнд | 1 | “Мон казе” ХХК -ийн гаргасан үнийн дүнгээр | | | 2025 онд | |
| 8 | Хог хаягдал зайлуулах | Хогийг зөвшөөрсөн цэгт зөөж зайлуулж байх | Талбайн хэмжээнд | Удаа | 40.0 | Сард 2 удаа /жилд 24 удаа/ | 3 сар*40.0=120.0 | 2025 онд | |
| **Нийт зардал** | | | | | | | | | **2 360.0** |




***Зураг 2. Хог хаягдлын цэгийн шийдэл***

Төслийн талбайд Хог хаягдлын цэгийг Байгаль орчин,аялал жуулчлалын сайдын 2018 оны 11 дүгээр сарын 17 өдрийн А/443 дугаар тушаалын хавсралт “Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах,тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага”-ын дараах заалтын дагуу барьж байгуулан ашиглах шаардлагатай.

Төслийн талбайд хийгдэх Хог хаягдлын цэгийг Зураг 2-д заасны дагуу битүүмжлэлтэй, цоожтой лист төмрөөр хийгдсэн байхаар хийх боломжтой ба хог хаягдлыг энгийн, дахивар, аюултай хог хаягдал зэрэг 3 ангилан ялгах нь зүйтэй.

***Хүснэгт14. Ангилан ялгах хог хаягдлууд***

| Энгийн хог хаягдал | Дахивар хог хаягдал | Аюултай хог хаядал |
|---|---|---|
| ✓ **Хоолны үлдэгдэл;**<br>✓ **Хүнсний ногоо, жимсний хальс, үлдэгдэл;**<br>✓ **Яс;**<br>✓ **Хэрэглэсэн хүнсний тос**<br>✓ **Аюултай болон дахин боловсруулах хог хаягдлаас бусад хог хаягдал** | ✓ Цаас /хэт бохирдоогүй сонин, сэтгүүл, дэвтэр, бичгийн цаас,төрөл бүрийн боодлын цаас,картон цаас, сүү, жүүсний тетрапак савлагаа/<br>✓ Хуванцар /төрөл бүрийн ус,ундааны хуванцар сав, 0,025 мм-ээс дээш зузаантай гялгар уут, баглаа боодол кетчуп, ургамлын тос, бие угаагч шингэн, шампунь, угаалгын шингэний хуванцар сав, гм/<br>✓ Хөнгөн цагаан, төмөр, метал, зэс, гууль, тэдгээрээр хийсэн зүйл;<br>✓ Шил /хүнсний болон бүх төрлийн шилэн сав, шилэн эдлэл/;<br>✓ Лааз;<br>✓ Мод, модон эдлэлийн хаягдал;<br>✓ Хувцас, даавуун эдлэл;<br>✓ Савхи, резин;<br>✓ Өвс, мод. | Аюултай хог хаягдал гэж амьтан, ургамлыг өвчлүүлэх, гэмтээх, тэдгээрийн үр удамд хор хөнөөл учруулах болон байгаль орчны хэвийн төлөв байдалд сөрөг нөлөөтэй хортой, идэмхий, исэлдүүлэгч, шатамхай, дэлбэрэх хог хаягдлыг хэлнэ.<br><br>Иймд Төслийн үйл ажиллагаанаас гарч буй нефть болон газрын тосны бүтээгдэхүүн агуулж буй сав, савны цэвэрлэгээнд ашигласан цэвэрлэгээний материал, тос тосон бүтээгдэхүүн агуулж буй савны хаягдлыг энэ цэгт төвлөрүүлж Хог хаягдал тээвэрлэх машинд ачуулж тусгай цэгт хүргүүлнэ. |

**Хог хаягдлыг цуглуулахад тавигдах ерөнхий шаардлага**

***2.3.1.*** *Энгийн хог хаягдлыг цуглуулах гэж Хог хаягдлын тухай хуулийн 4.1.8-д заасныг ойлгох ба хуулийн 14 дүгээр зүйлд заасныаас гадна энэхүү тавигдах ерөнхий шаардлагын 2.3.2-2.3.5-д заасан ерөнхий шаардлага хамаарна.*

***2.3.2.*** *Хог хаягдлын тухай хуулийн 14.2-т заасан гэрээнд хог хаягдал цуглуулах төрөл, хэлбэр, хогийн цэгийн байршил, ажиллах цагийн хуваарь, орчны тохижилт, ариун цэврийн шаардлагын талаар тодорхой тусгасан байна.*

***2.3.3.*** *Хог хаягдлыг цуглуулах зориулалт бүхий сав, төхөөрөмж гэж энгийн хог хаягдлыг тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах зорилгоор хог хаягдлыг цуглуулж байгаа хог хаягдал үүсгэгчийн ойролцоо байршуулсан савыг хэлэх ба  дараах ерөнхий шаардлага хангасан байна.*

*а. Хог хаягдал цуглуулах сав, төхөөрөмжийг сум, хорооны Засаг даргын зөвшөөрсөн хэлбэр, хэмжээ, зориулалт болон заасан газарт байгуулна.*

*б. Орон сууцны хороолол, нийтийн эзэмшлийн талбай, явган хүн, авто машины хөдөлгөөнд саад учруулахааргүй газар байна.*

*в. Хог хаягдал хийсэх, агаар болон хөрсөнд тархах, шингэх, уусах, үнэр тархахгүй нөхцөлийг бүрдүүлсэн байна.*

*г. Хог хаягдлын төрөл, ангиллын мэдээллийг ил харагдахуйц байршуулсан байна.*

*д. Байгаль орчинд сөргөөр үл нөлөөлөх нөхцөлөөр буюу чанарын шаардлага хангасан байна.*

*е. Тээвэрлэх зориулалт бүхий уяа, дэгээтэй, хог хаягдал ачих тээврийн хэрэгсэлд зориулагдсан байна.*

*ж. Хог хаягдал цуглуулах зориулалт бүхий сав, төхөөрөмжийн хог хаягдал хадгалах, цуглуулах багтаамж 3 хоногоос ихгүй байна.*

***2.3.4.*** *Хог хаягдал цуглуулах иргэн, аж ахуй нэгж, байгууллагын ажилтан нь дараах ерөнхий шаардлагыг хангасан байна.*

*а. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зохих мэдлэгтэй байх;*

*б. Хөдөлмөр хамгааллын нэг бүрийн хэрэгсэл хэрэглэх;*

*в.Хог хаягдал цуглуулах үйл ажиллагааны бүрэн мэдлэгтэй, хог хаягдал үүсгэгчийн онцлогийг тодорхойлох чадвартай байх.*

***2.3.5.*** *Хог хаягдлын цуглуулахдаа ангилан ялгасан хог хаягдал тус бүрээр цуглуулна.*

# БҮЛЭГ 11. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хог хаягдлын менежмент гэдэг нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд хог хаягдлаас үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор хог хаягдлын эх үүсвэрийг бууруулах, ангилан ялгах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, устгах бүхий л процессыг хянаж сайжруулах зохион байгуулалтын арга хэмжээ юм.

2025 оны Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний дагуу Далан-Ухаа уурхай нь Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Засаг даргын тамгын газартай хамтран хог хаягдлын гэрээг хийнэ.

Төсөл хэрэгжүүлэгч нь хог хаягдлын менежментийн хүрээнд цаашдын авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх, хог хаягдлыг газар дээр нь ангилан ялгах нөхцөл бололцоог хангаж ажиллах үүрэгтэй.

Эзэмшил газрынхаа ойр орчны цэвэрлэгээг тогтмол хийх, үйл ажиллагааны явцад үүсэх хог хаягдлыг тогтоосон цэгт хуримтлуулж тогтмол хугацаанд зайлуулах, ангилан ялгаж дахин ашиглах боломжтой хаягдлыг ашиглах, аливаа зүйлээр бохирдсон хог хаягдлыг саармагжуулах, галын аюулаас хамгаалах, хадгалалт хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хүрээнд төслийн үйл ажиллагаанаас үүсэх хог хог хаягдлын сөрөг нөлөөллийг буруулах, багасгах хянах үүднээс авч хэрэгжүүлэх арга хэмжээг доорх хүснэгтэд боловсруулж оруулсан болно.

Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж хадгалахдаа хогийн сав болон хогийн цэгийг өнгөөр ялгаж зургаар тэмдэгжүүлснээр хуурай хог хаягдлыг стандартын дагуу ачиж, тээвэрлэх хадгалах нөхцөл бүрдэхээс гадна байгаль орчинд сөрөг нөлөөгүй бохирдолгүй амьдрах нөхцөл бололцоо бий болох юм.

Хатуу хог хаягдлаа ялган ангилсны ач холбогдол:

- Цаас, шил, мод, яс, хуванцар, металл, оргаНик гаралтай хаягдлыг эргүүлэн ашиглах, дахин боловсруулах боломж бий болно.
- Орчныг бохирдуулах, устгал хийх хогны хэмжээ эрс багасна.
- Хог хаягдлыг байгаль орчинд халгүйгээр ачиж тээвэрлэх боломж бүрдэнэ.
- Хүн амын аюулгүй, цэвэр, эрүүл орчинд ажиллах, амрах нөхцөл бүрдэнэ.
- Амьтан, ургамал, хөрс, усанд үзүүлэх сөрөг нөлөөлөл багасах зэрэг олон талын ач холбогдолтой юм.

***Хүснэгт 15. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө***

| Төлөвлөсөн арга хэмжээ | Урьдчилан тооцсон төсөв | Хэрэгжүүлэх хуваарь | | | | Хариуцсан албан тушаалтан | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2025 | | | | | |
| | | I улирал | II улирал | III улирал | IV улирал | | |
| Мэргэжлийн байгууллагатай хамтран хөдөлмөр хамгаалал, байгаль орчныг хамгаалах, гал түймрээс урьдчилсан сэргийлэх талаар ажил эхлэхийн өмнө сургалт, сурталчилгааг хийх | 500.0 | | | | + | | |
| Байгаль орчныг хамгаалах, хог хаягдлаа тогтоосон цэгт хаях, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар сурталчилгааны самбар гаргаж, шинэчилж байх | 200.0 | | | | + | | |
| Гал түймэртэй тэмцэх багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмж авах, хөдөлмөр хамгаалал, эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээний тоноглолуудыг зохих газарт байнга бэлэн байлгах | 240.0 | | | | + | | |
| Ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах, эрүүл мэндийн тандалт судалгаа хийх | Дотоод төлөвлөлтөөр | | | | + | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Галын аюулгүй байдлын дүгнэлтийг Онцгой байдлын хэлтсээр гаргуулах | Дотоод төлөвлөлтөөр | | | | + | | |
| Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа | | | | | + | | |
| Гамшгийн эрсдэлийн үнэлгээ жилд нэг удаа хийлгэх | Дотоод төлөвлөлтөөр | | | | | | |
| Орон нутгийн удирдлагатай нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж хамтран ажиллах | | | | | + | | |
| **Нийт зардал, мян.төг** | **940.0** | | | | | | |

# БҮЛЭГ 12. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

БОННҮ-ний тайлан, БОХТ-нд тусгасан болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, Төслийн үйл ажиллагаанаас үүдэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд ажиглалт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг “орчны хяналт шинжилгээний хөтөлбөр” гэнэ. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь “Баяжуулах үйлдвэрийн бүс” төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд гарч байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлох, болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилготой. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт дараах зүйлсийг тусгасан байх болно. Үүнд

- Байгаль орчны бүрэлдэхүүн тус бүрт үзүүлэх нөлөөлөл;
- Хяналт-шинжилгээ явуулах зайлшгүй шаардлагатай үзүүлэлтүүд;
- Хяналт-шинжилгээ явуулах төрөл, хэлбэр;
- Хяналт-шинжилгээ хийх, сорьц авах цэгийн байршил;
- Хяналт-шинжилгээ явуулах хугацаа, давтамж;
- Хяналт-шинжилгээ явуулах арга, аргачлал;
- Хяналт-шинжилгээ явуулахад шаардлагатай техник, тоног төхөөрөмж;
- Хяналт-шинжилгээний үр дүнг нэгтгэх, тайлагнах арга, хэлбэр зэрэг болно.

Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь төслийг хэрэгжүүлэх явцад үүссэн сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах үйл ажиллагаа ямар үр дүнтэй байгааг илтгэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, орон нутгийн захиргаа болон нутгийн нутгийн иргэдэд бодит мэдээлэл өгөхөд чухал ач холбогдолтой..

БОХШХ нь байгаль орчин, нийгэм-эдийн засгийн үнэт зүйлсийг хамгаалах, түүнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагаа нь ямар үр дүнтэй байгааг илтгэх үндсэн баримт бичиг болно. Цаашдаа БОХТ-г улам боловсронгуй болгох байгаль орчин, нийгэм-эдийн засгийн болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг илүү нарийвчлан тогтоох боломжтой болно.

БОМТ-г жил бүр шинэчлэн боловсруулж тухайн оныхоо эхэнд БОУАӨЯ-аар батлуулж, оны эцэст тэдгээрийн биелэлтийг мөн БОУАӨЯ-д тайлагнана. Хяналт-шинжилгээний дээж, сорьцыг МУ-ын болон гадаадын итгэмжлэгдсэн лабораториудад батлагдсан аргазүй, стандартын дагуу шинжлүүлнэ.

Хяналт шинжилгээний үр дүнг хянах үйл ажиллагааг хөндлөнгийн мэргэжлийн байгууллагуудаар, хороо дүүргийн хөндлөнгийн хяналтын доор гүйцэтгэх зэргээр оролцогч талуудын хяналтыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах нь зүйтэй юм.